

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: САЙХАН СУМЫН ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН
УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСӨВ САНХҮҮТЭЙ ХОЛБООТОЙ
АЛБАН ХААГЧДААС ИРСЭН ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ**

УДИРДАМЖИЙН КОД: №02

2024

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ХАМРАГДЛАА.

АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА: 2024.05.14-2024.06.06

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮД:

ДОТООД АУДИТОР, СХШУБ Ц.УРТНАСАН

ДОТООД АУДИТОР Г.ДОРЖДЭРЭМ

Тайлан бэлтгэсэн:

Санхүүгийн хяналт, дотоод
аудитын алба

Албаны дарга, СХШУАБ
Т.Одсүрэн

Дотоод аудитор СХШУБ
Ц.Уртнасан

Дотоод аудитор
Г.Дорждэрэм

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал

Sankhuu_audit_Se@yahoo.com
мэйл хаягаар харилцана уу.

ХАЯГ: Сүхбаатар сум Орхон 6
дугаар баг, Нутгийн
удирдлагын II ордон, 1 давхар

2024 оны 06 дугаар сар

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ, хязгаарлалт

2.3 Аудитын арга зүй

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1 Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Хот тохижилтын газар нь 1997 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс "Дөмбөн Сайхан" /ОНӨААТҮГ/ нэртэйгээр тусдаа бие даасан байгууллага болон гарч Сайхан сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах 12 дугаар байрны 16-17 тоот нэг давхарт 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа эхэлсэн ба 2014 оноос хойш Сайхан сумын Хот тохижилтын газар нэртэйгээр, үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь Сайхан сумын нийтийн эзэмшлийн зам талбай, тээврийн хэрэгслийн зорчих замын хэсгийн цэвэрлэгээ, авто зам болон гэр хорооллын гэрэлтүүлэг, айл өрх аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын тээвэрлэлт, нэгдсэн хогийн цэгийн цэвэрлэгээ, устгал, парк наадмын талбайн цэвэрлэгээ, засвар, ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, зэрэг ажлуудыг хариуцан хийж ажиллаж байна.

2023, 2024 онд батлагдсан бүтэц орон тоо 24, үүнээс 2023, 2024 онд орон тооны хангалт 100 хувиар ажилласан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Сайхан сумын Хот тохижилтын газрын удирдлагын үйл ажиллагаатай холбоотой гаргасан гомдолд дурдсан асуудлыг шалгаж дүгнэлт гаргах зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Сайхан сумын Хот тохижуулах газрын удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар Тус газрын 2023-2024 оны үйл, ажиллагаа, төсөв, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, гомдолд дурдсан дараах асуудлыг хамрууллаа. Үүнд:

- Албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлс, урамшууллын тооцоолол, олголт
- Орон нутгийн нэмэгдлийг хууль тогтоомжид заасны дагуу олгосон эсэх
- Ажлаас халсан, нөхцөл байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх
- Тэтгэвэрт гарсан иргэнийг ажилд авч ажиллуулахдаа ялгаварлан гадуурхаж хууль тогтоомж зөрчсөн эсэх
- Өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
- Тээврийн хэрэгслийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн байдал
- Хог тээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчилсөн
- Хогны машин авах байсныг кран авсан асуудал
- Албан хаагчдын дансаар зориулалт бусаар мөнгө дамжуулан ашигласан эсэх

Аудитын гүйцэтгэхэд хязгаарлалт тогтоогоогүй, болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авлаа. Аудитын эдгээр горимын үр дүн, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль.
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 “Жишиг норм батлах тухай” тушаал.
- Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2020.
- Хог хаягдлын тухай хууль.
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль.
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам.

2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 03-ний өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч) Т.Одсүрэн хянан удирдаж, аудитын багийн ахлагчаар Дотоод аудитор (Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч) Ц.Уртнасан, гишүүнд Дотоод аудитор Г.Дорждэрэм нар гүйцэтгэв.

3. Байгууллагын сайн туршлага

Сайхан сумын Хот тохижилтын газар нь аж ахуй нэгж, орон сууцны айл өрхийн ойр орчимд хог ялган ангилах хогийн сав байрлуулсан, гэр хорооллын айл өрхийн хогийг авахдаа шуудайлуулж хэвшсэн нь ил задгай хог хаягдал тарахгүй байх, хог ачигч нарын ажлыг хөнгөвчилсэн сайн туршлага болсон байна.

Сайхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2010 оны 43 тогтоолоор хог хаягдлын сарын хураамж гэр хороолол 2,500 төгрөг, орон сууц 2,000 төгрөг, аж ахуйн нэгж 5,000-24,000 төгрөгөөр тооцож тогтоосон. 2022 оны 12 сарын 20-ны өдрийн 53 тогтоолоор Хот тохижилтын газрын хог хаягдлын сарын хураамжийг гэр хороолол 7,000 төгрөг, орон сууц 6,000 төгрөг, аж ахуйн нэгж 30,000 төгрөгөөр тооцож тогтоосныг Монгол улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны 7 арын 21-ний өдрийн 1/3960 дугаар албан тоотоор захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6315 дугаарт бүртгэснийг мэдэгдсэний дагуу үнэ тарифт 2023 оны 8 сарын 1-ний өдрөөс өөрчлөлт орсон байна.

3.1 Засаглалын талаар

Сайхан сумын Хот тохижилтын газар нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулаагүй. 2023 онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хогийн цэг түрж, далан бий болгож, авто тээврийн хэрэгсэл худалдан авсан байна.

Сайхан сумын Хот тохижилтын газар нь бүтэц орон тоогоороо нийт 24 хүний орон тоотойгоос 2023-2024 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 26 иргэнийг ажилд томилж, мөн хугацаанд хөдөлмөрийн гэрээг цуцалсан 18 ажилтан байгаа нь нийт ажилчдын 75 хувийг эзэлж байна.

Энэ нь тус газрын удирдлагын шийдвэр гаргах түвшин, хүний нөөцийн бодлого төлөвлөлт алдагдсан засаглалын хувьд эрсдэл өндөртэй байгаа нь байгууллагыг удирдаж байгаа хүнээс шууд хамааралтай байна.

Иймд хүний нөөцийг тогтвортой ажиллуулах удирдлагын менежментийг сайжруулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Сайхан сумын Хот тохижилтын газар нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, ба тохижилт үйлчилгээ хариуцсан зохион байгуулагчийг хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад хамруулсан байна.

Удирдлага нь эрсдэлийн талаар ойлголтгүй, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг сайжруулах, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлээгүй, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх стратеги, зарчим, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, байгууллагын хэмжээнд эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, хянах, тайлагнах үйл явцыг төлөвшүүлэн, эрсдэлийн мэдээллийн сан, дотоод хяналт, эрсдэлийг удирдах соёл, хандлага, чадавхыг төлөвшүүлээгүй байна.

3.3 Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам”-ын хүрээнд цэцэрлэгийн “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг батлан мөрдөж, дотоод хяналтын комисс ажилладаг.

Сайхан сумын Хот тохижилтын газар нь 2023, 2024 онд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын удирдлагын зүгээс хууль тогтоомжид заасан үүргээ хэрэгжүүлж дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг улирал бүр дүгнэж эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах шаардлагатай.

4. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Албан хаагчдын цалин, хөлсийг 2023 оны 7, 9 дүгээр саруудад сар дамнуулан олгосон байна.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Сайхан сумын Хот тохижилтын газар нь 2023 оны 07 сард 18,668,938 төгрөгийн, 09 сард 23,732,077 мянган төгрөгийн, нийт 42,401,015 төгрөгийн цалинг сар дамжуулж ажилтан албан хаагчдад олгосон нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаагүй нөхцөл байдал үүссэн нь хяналт шалгалтын явцад тогтоогдсон.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөдөлмөрийн тухай хуулийн /2021 оны шинэчилсэн найруулга/ 104.1.Цалин хөлсийг сард хоёроос доошгүй удаа тогтсон өдөр олгох бөгөөд олгох өдрийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, эсхүл хөдөлмөрийн гэрээнд тусгана. Хот тохижуулах газрын даргын 2023 оны 01 сарын 03-ны өдрийн А/2 тушаалаар шинэчлэн батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.1. "Ажилтны ажилласан цагийг цагийн бүртгэлээр баталгаажуулж сард нэг удаа буюу сарын сүүлд цалин бодож олгоно."	
Асуудлын үндсэн шалтгаан: 2023 оны 7 сард Хот тохижилтын газрын дарга, 9 сард Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга ээлжийн амралттай, өөр газарт байсан учир сарын санхүүжилтийг хугацаандаа авч чадаагүйгээс шалтгаалсан байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: <ul style="list-style-type: none"> • Байгууллагын төсөв, санхүү хугацаандаа батлагдахгүй байх, • Удирдах албан тушаалтнуудын хяналт, уялдаа холбоо муу байх, • Ажилтан, албан хаагчдыг хохироох 	
Шийдвэр: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, цалин хөлсийг хууль тогтоомжид заасны дагуу олгож байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 2	Тус газрын 2024 оны төсвийг сумын ИТХ-аас батлахдаа төсвийн орлогоос шалтгаалан орон нутгийн нэмэгдлийг өмнөх оноос 30 хувиар бууруулан баталсан асуудлыг албан хаагчдад мэдэгдээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: Орон нутгийн нэмэгдлийг хууль тогтоомжид заасны дагуу олгосон эсэхийг хяналт шалгалтын явцад холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр нэмэгдлийг олгосон санхүүгийн баримтаар баталгаажуулахад 2023 онд орон нутгийн нэмэгдлийг 50 хувиар тооцож бүрэн олгосон байна. Гэвч сумын төсвийн орлогоос шалтгаалан 2024 оны төсвийн ИТХ-аар батлахдаа орон нутгийн нэмэгдлийн өмнөх онд олгож байсан хувь хэмжээгээр олгох боломжгүйгээс 20 хувийн нэмэгдэл олгохоор баталсан байна. Сайхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 20 тогтоолоор Хот тохижилтын газрын 2023 оны батлагдсан төсөв 512,270,400 төгрөг, 2023 оны 25 тогтоолоор 2024 оны батлагдсан төсөв 466,496,100 төгрөг байна. 2024 оны батлагдсан төсөв өмнөх оноос 45,774,300	

төгрөгөөр буурч батлагдсан нь дээрх орон нутгийн нэмэгдэл олгох зардал буурсантай холбоотой байна.

2024 онын 1-4 сарын хугацаанд орон нутгийн нэмэгдлийг бүх албан хаагчдад батлагдсан төсвийн хүрээнд 20 хувиар тооцож олгосон нь цалин хөлсний тооцоол, албан хаагчдын цалингийн цэс болон олгосон баримтаар нотлогдож байгаа нь гомдолд дурдсан асуудал үндэслэлгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 489 тогтоолын 5-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчид 80 хүртэл хувиар нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно."

Асуудлын үндсэн шалтгаан:

2024 оны батлагдсан төсөв өмнөх оноос 45,774,300 төгрөгөөр буурснаар тухайн байгууллагын орон нутгийн нэмэгдлийг бууруулах шалтгаан болсон ба энэ талаар ажилтан, албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой мэдээллийг өгөөгүйгээс удирдах албан тушаалтан, ажилчдын дунд цалин бууруулсан асуудал нь гомдол гаргах үндсэн шалтгаан болсон байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Байгууллагын удирдлага, албан хаагчдын дунд үл ойлголцол, үл итгэлцэл үүссэн.
- Ажил дээр хэл ам гарах, албан хаагчдын дунд хагарал үүсэх, ажил удаашрах, ажлаас гарах гэх мэт байгууллага, ажилтнуудад хохиролтой нөхцөл байдал үүссэн байна.

Шийдвэр:

Албан хаагчдад цалин хөлс. Нэмэгдэлд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажилтан албан хаагчдад тухай бүр хүргэж төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 3	Хот тохижилтын газрын хүний нөөц тогтворгүй, ажилтны санаачилгаар болон ажил олгогчийн санаачилгаар 2023 онд батлагдсан орон тооны 50 хувьтай тэнцэх, 2024 оны 4 сарын байдлаар 25 хувьтай тэнцэх тооны ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал:	<p>Ажлаас халсан, нөхцөл байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлыг шалгахад 2023 онд 19 хүнийг ажилд авч 12 хүн ажлаас гарсан ба ажлаас гарсан 12 ажилтнаас 7 нь өөрийн хүсэлтээр буюу ажилтны санаачилгаар, 5 нь ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан байна.</p> <p>2024 онд 7 хүнийг ажилд авч 6 хүн ажлаас гарсан бол ажлаас гарсан 6 ажилтнаас 3 нь өөрийн хүсэлтээр буюу ажилтны санаачилгаар, 3 нь ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан байна.</p> <p>Албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдолд гэр хорооллын байцаагчаар ажиллаж байсан Д.Мядагмааг ажлаас халсан үндэслэл нь хууль, хөдөлмөрийн гэрээ зөрчсөн эсэхийг тодруулахыг хүссэн байсан.</p> <p>Тус газрын 3-р хэсгийн орлогын байцаагчаар ажиллаж байсан Д.Мядагмаагийн хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болсон тул даргын 2022 оны 04 сарын 21-ний өдрийн Б/21 тушаалаар Д.Мядагмааг 3-р хэсгийн орлогын байцаагчаар томилж, хөдөлмөрийн гэрээг сунгасан байна.</p> <p>➤ 2023 оны 05 сарын 10-ны өдрийн Б/31 тушаалаар Д.Мядагмаа, А.Отгонцэцэг нар нь ажлын байран дээр хэл ам хэрүүл тэмцэл хийж бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлэн муугаар нөлөөлөх, бусдыг хэл амаар доромжлох, бусдыг уриалан турхирах ёс зүйгүй үйлдэл гаргаж, хамт олны дунд таагүй байдал үүсгэн, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд</p>

<p>сөргөөр нөлөөлсөн тул сануулах сахилгын шийтгэл оногдуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хот тохижуулах газрын 2023 оны 09 сарын 22-ны өдрийн хурлаар Д.Мядагмаад орлогын төлөвлөгөө тасалдуулж, тайлан тооцоог хойшлуулан, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, ажлын байран дээр хэрүүл хийж бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлсэн, хамт олны дунд таагүй уур амьсгал бүрдүүлсэн, ажлын гүйцэтгэл муу байгааг үндэслэн 2023 оны 09 сарын 26-ны өдрийн Б/80 тушаалаар 9-р сарын үндсэн цалинг 10 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан. ➤ 2024 оны 04 сарын 22-ны Б/26 дугаар тушаалаар Д.Мядагмааг гүйцэтгэж байгаа ажил мэргэжилдээ мэдлэг ур чадварын хувьд тэнцэхгүй болсон ба тухайн ажилтанд өмнө нь анхааруулж ажлын гүйцэтгэлээ сайжруулах боломж олгосон боловч түвшин ахиагүй тул хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож ажил олгогчийн санаачилгаар орлогын байцаагчийн албан тушаалаас чөлөөлөх шийдвэрийг Хот тохижуулах газрын 2024 оны 04 сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэл байна. <p>Ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан боловч 2022 оны Б/17 тушаал, 2023 оны Б/31 тушаалын үндэслэл болох ажилчдын хурлын тэмдэглэл байхгүйгээс уг тушаалуудаар оногдуулсан сахилгын шийтгэл үнэн эсэх нь нотлогдохгүй байна.</p> <p>Хөдөлмөрийн гэрээний үндсэн нөхцөл буюу 2.3-т “сар бүр орлогын төлөвлөгөөний дагуу ажил үүргээ биелүүлж түүгээр нь дүгнэх үзүүлэлт болгоно” гэж тусгасан ба орлогын байцаагч Д.Мядагмаа нь өөрийн хариуцсан 3-р багийн орлогын төлөвлөгөөг 2023 онд 80 хувь, 2024 оны 4 сарын байдлаар 22 хувиар биелүүлсэн байна.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Ажиллах орчин нөхцөл хүнд, ▪ Цалин, урамшуулал бага, ▪ Удирдлага ажилчидтайгаа харилцах хандалга буруу, ▪ Ажилтан нь ажлын байрны шаардлагад тэнцэхгүй байх. 	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Байгууллагын удирдлагын буруу шийдвэрээс шалтгаалж Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, ▪ Ажилтны хөдөлмөрлөх эрхийг хязгаарласнаар хөдөлмөрийн маргаантай холбоотой сөрөг үр дагавар бий болох, ▪ Хамт олны дунд таагүй байдал үүсэх, ▪ Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх 	
<p>Шийдвэр:</p> <p>Д.Мядагмаа нь Хот тохижуулах газрын даргын 2024 оны 04 сарын 22-ны Б/26 дугаар тушаалыг үндэслэлгүй гэж үзэж байгаа тохиолдолд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхээр шийдвэрлүүлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.</p>	

Илэрсэн асуудал 4	Тэтгэвэр тогтоолгосны дараах хөдөлмөр эрхлэлтэй холбоотой тус байгууллагад Тохижилт, үйлчилгэ хариуцсан зохион байгуулагчаар ажиллаж байсан А.Отгонцэцэгтэй холбоотой гомдол нь үндэслэлгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө бага
<p>Бодит байдал:</p> <p>Хот тохижуулах газарт 2023 онд тэтгэвэрт гарсан А.Отгонцэцэг /зохион байгуулагч/, Б.Жанчив /хог тээврийн ачигч/, Ч.Гавьяат /зам талбайн үйлчлэгч/ Ц.Төмөрбаатар /цахилгаанчин/, Ц.Арьяадайрий /жолооч/, С.Заяахүү /орлогын байцаагч/ нийт 6 албан хаагч, 2024 онд Б.Жанчив /хог тээврийн ачигч/, Ц.Төмөрбаатар /цахилгаанчин/, С.Заяахүү /орлогын байцаагч/ нийт 3 албан хаагч ажилласан байна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ 2023 оны 12 сард Ц.Төмөрбаатар ажлаас гарч 2024 оны 2 сард цахилгаанчин А.Дагвадоржийг ажилд авсан ч тухайн сардаа ажлаасаа гарснаар 2024 оны 3 сарын 1-ний өдрөөс өөр мэргэжилтэн олдохгүй байсан учир цахилгааны доголдлыг арилгахын тулд Ц.Төмөрбаатарыг эргүүлэн ажилд авсан. ➤ Хог тээврийн ачигч Б.Жанчив 2023 оны 1-3 сард зам талбайн үйлчлэгчээр ажиллаж 	

<p>байгаад эрүүл мэндийн шалтгаанаар ажлаасаа гарч 2023 оны 11 сард буцаж ачигчаар ажилд орж, 2024 оны 4 сард өөрийн хүсэлтээр, ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын даргын зөвлөл хурлын шийдвэрээр 2021 оны 10 сараас хог хаягдлын хураамжийн төвлөрүүлэлт муу, их хэмжээний авлагатай байсан учир тэтгэвэртээ гарсан орлогын байцаагчаар ажиллаж байсан С.Заяахүүг ажилд авсан байна. С.Заяахүү нь 2023 оны орлогын төлөвлөгөөг 263 хувь, 2024 оны 4 сарын байдлаар орлогын төлөвлөгөөг 104 хувиар биелүүлсэн байна. ➤ Хот тохижилтын газрын даргын 2023 оны 01 сарын 02-ны өдрийн Б/3 тушаалаар А.Отгонцэцэгийг тохижилт үйлчилгээ хариуцсан зохион байгуулагчаар 1 жилийн хугацаатайгаар хөдөлмөрийн гэрээг сунгаж ажиллуулсан. 2023 оны 12 сарын 28-ны өдрийн Б/96 дугаар тушаалаар хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан тул ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлсөн. <p>Албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдолд зохион байгуулагчаар ажиллаж байсан А.Отгонцэцэгийн хөдөлмөрийн гэрээг үргэлжлүүлэн сунгаагүй, ажиллуулахгүй ялгаварлан гадуурхаж, хууль тогтоомж зөрчсөн эсэхийг тодруулахыг хүссэн байсан.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хот тохижилтын газрын даргын 2023 оны 05 сарын 10-ны өдрийн Б/31 тушаалаар Д.Мядагмаа, А.Отгонцэцэг нар нь ажлын байран дээр хэл ам хэрүүл тэмцэл хийж бусдад буруу үлгэр дуурайлал үзүүлэн муугаар нөлөөлөх, бусдыг хэл амаар доромжлох, бусдыг уриалан турхирах ёс зүйгүй үйлдэл гаргаж, хамт олны дунд таагүй байдал үүсгэн, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн тул сануулах сахилгын шийтгэл оногдуулсан. ➤ Хот тохижилтын газрын даргын 2023 оны 12 сарын 28-ны өдрийн Б/96 дугаар тушаалаар А.Отгонцэцэгийн хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан тул ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлсөн байна. Хөдөлмөрийн гэрээгээр 1 жилийн хугацаа нь 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр дуусах байсан боловч 2023 оны 12 сарын 28-ны өдрийн Б/96 дугаар тушаалаар ажил олгогчийн санаачилгаар ажлын 1 өдрийн өмнө ажлаас чөлөөлсөн байна. 	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөдөлмөрийн тухай хууль, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Тэтгэвэрт гарсан иргэнтэй харилцан тохиролцож 1 жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан ба гэрээний хугацаа дуусахтай холбогдуулан ажлын байрны сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлж тухайн албан тушаалд ажиллах хүсэлт гаргасан 3 иргэний материал ирсэн байна. Мөн 2024 онд А.Отгонцэцэг нь цаашид үргэлжлүүлэн ажиллах хүсэлтийг байгууллагын удирдлагад гаргаагүй байна. Иймд Ажил олгогчийн зүгээс А.Отгонцэцэгтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг үргэлжлүүлэн сунахгүйгээр гэрээний хугацааг дуусгавар болгосон нь Хөдөлмөрийн тухай хууль болон гэрээгээр талууд хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох хугацааг 78.1.1 дэх заалтын дагуу харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээгээр баталгаажуулсан байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөх хууль эрх зүйн үндэслэлийг буруу гаргаснаас хөдөлмөрийн маргаан үүсэх, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтан хохирлыг бүрэн барагдуулах сөрөг үр дагавар бий болно.</p>	
<p>Шийдвэр: Ажилд авах, ажлаас чөлөөлөх үед хууль зүйн үндэслэлийг зөв тодорхойлж байх</p>	

<p>Илэрсэн асуудал 5</p>	<p>Сайхан сумын төсөвт хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг 2023 онд 65,169,150 төгрөгөөр, 2024 онд 78,832,000 төгрөгөөр дутуу тооцож батлуулсан байна. Хог хаягдлын хураамжийн орлогыг санхүүгийн программд бүртгээгүй.</p>
---------------------------------	---

Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сайхан сумын Хот тохижилтын газрын орлогын төлөвлөгөөг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 44 тогтоолоор 2023 онд 34,000,800 төгрөг, иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 25 тогтоолоор 2024 онд 80,000,000 төгрөгөөр тогтоосон. Үнэ тарифт өөрчлөлт орсон боловч сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хог хаягдлыг хураамжийн орлогын төлөвлөгөөг нэмээгүйгээс гүйцэтгэл 61,102,862 төгрөг буюу 180 хувиар давуулан биелсэн байна. 2024 оны 4 сар хүртэлх орлогын төлөвлөгөөний хуваарийн дагуу 42,728,000 төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэл 32,671,600 төгрөг буюу орлогын биелэлт 76 хувьтай байна. 2. Аж ахуй нэгж, айл өрхийн тоог тухайн үед мөрдөгдөж буй үнийн тарифаар тооцвол 2023 онд 99,169,950 төгрөгөөр төлөвлөгдөх орлогыг 34,000,800 төгрөгөөр, 2024 онд 158,832,000 төгрөгөөр төлөвлөгдөх орлогыг 80,000,000 төгрөгөөр тогтоосноос 2023 онд 65,169,150 төгрөгөөр, 2024 онд 78,832,000 төгрөгөөр дутуу тооцсон байна. 3. Хот тохижилтын газрын орлогын байцаагч нар нь аж ахуй нэгж, айл өрх тус бүрээр бүртгэж авлага, орлого бүртгэдэг 2012 онд нэвтрүүлсэн Express Account NNB программ ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэл дээр санхүүгийн CTS NNB программ ашигладаг боловч 2023, 2024 оны аж ахуй нэгж, айл өрхийн авлага, өөрийн орлогыг санхүүгийн тайлан, санхүүгийн программд огт тусгаагүй, орлогыг хянаж тулгадаггүй байна. Үүнд: 2023 оны жилийн эцэст 34,846,620 төгрөгийн авлага, 2024 оны 1-р улирлаар 56,118,000 төгрөгийн авлага үүссэнийг, хаан банкин дахь харилцах дансанд орсон өөрийн орлого 2023 онд 61,102,862 төгрөг, 2024 онд 32,671,600 төгрөгийг санхүүгийн тайлан, санхүүгийн программд огт бүртгээгүй байна. 	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт".14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"бүх орлого"</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сайхан сумын төсөвт хог хаягдлын хураамжийн орлогыг урьд оны орлогын биелэлтийг үндэслэн, тухайн үед мөрдөгдөж буй үнэ тарифын үнэлгээгээр нарийн тооцоолоогүйгээс шалтгаалж хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг 2023 онд 65,169,150 төгрөгөөр, 2024 онд 78,832,000 төгрөгөөр дутуу тооцсон байна 2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж ажиллаагүй 3. Байгууллагын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул байна 	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Өөрийн орлогыг дутуу төлөвлөснөөс төсөвт төвлөрүүлэх орлого буурах, ▪ Орлогыг бүртгэлд тусгаагүйгээс байгууллагын санхүүгийн тайлан, сумын нэгтгэл тайлан буруу гарах, байцаагч нарын авлага, орлогын хяналт муу байх, ▪ Байгууллагын үр ашгийг буруу тооцох 	
<p>Шийдвэр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Орлогын төлөвлөгөөг бодитой тооцож төсөвлөх, батлуулах, орлогын байцаагч нарт тавих хяналтыг чанаржуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв. 2. Санхүүгийн программд 2024 оны 1-р улиралд 56,118,000 төгрөгийн авлага үүссэнийг, хог хаягдлын хураамжийн орлого 32,671,600 төгрөгийн орлогыг санхүүгийн CTS NNB программд бүртгэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. 	
Илэрсэн асуудал 6	Худалдан авах ажиллагааг босго үнийн худалдан авах аргыг ашиглаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: 2023 онд 33,200,000 төгрөгийн, 2024 онд 33,000,000 төгрөгийн тээвэр шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр “Шунхлай” ХХК-аас шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. 2024 оны 05 сарын 21-ний өдрийн байдлаар 10,300,000 төгрөгийн шатахууныг Шунхлай ХХК-аас худалдан авсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.”, ТБОНӨХБАУХАТ Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1. дэх “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна.”, 31.1.2. дэх “харьцуулалт.”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20 сая төгрөг, ажил -20 сая төгрөг”	
Асуудлын үндсэн шалтгаан: 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас дээрх зөрчилд албан шаардлага өгсөн. 2024 онд уг алдаа зөрчлийг залруулахгүй, давтан гаргасан байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Зөрчлийг залруулахгүй давтан гаргах нь байгууллагын удирдлагын санхүүгийн сахилга бат хангалтгүй, сайжруулах хүсэлгүй санаатай үйлдэл мэт харагдаж байна. Энэ нь жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар тухайн байгууллага, сумын нэгтгэлийн зөрчлийн дүнд сөргөөр нөлөөлнө	
Шийдвэр: Цаашид худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан тендер шалгаруулалтын аргыг сонгохдоо босго үнийг баримталж ажиллуулах зорилгоор зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 7	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ цаг хугацаанд нь хийгдээгүйн улмаас хог тээвэрлэх зориулалттай 3 автомашины ашиглалт маш хангалтгүй байна
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Хог тээврийн Toyota Dyna, Mitsubishi Canter, Isuzu elf авто машинуудыг 2023 онд Сэлэнгэ аймгийн авто тээврийн газрын техникийн хяналтын үзлэгт хамруулахад “хэвийн буюу тэнцсэн” дүгнэлтийг өгсөн байна. Гэвч аудитын явцад уулзалт, ярилцлага хийн гомдолд дурдсан асуудлыг тулган баталгаажуулахад хог тээврийн машинд нэн шаардлагатай сэлбэг хэрэгслийг авч өгөөгүй, үүнээс шалтгаалж 13-51 СБА дугаартай Toyota Dyna машин тоормосгүйгээр ажиллуулсан гэсэн гомдлыг удирдлагын зүгээс хүлээн зөвшөөрсөн. Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийн хөтлөлтөд засвар үйлчилгээ хийсэн, олгосон сэлбэг хэрэгслийн /хийц, хийсэн их засвар, дугуй, аккумулятор, астатчер зэрэг/ мэдээллийг тусгасан боловч автомашины засвар үйлчилгээнд зарцуулсан гэх сэлбэг хэрэгслийг шаардах хуудсыг үндэслэн зарлагдсан нь анхан шатны баримтын бүрдэл буюу зарцуулалтыг нотлох техникийн эвдрэл гэмтлийг тодорхойлсон ашиглалтын норм, хугацаа дууссан эсэхийг тодорхойлсон техникийн комиссын акт, өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлсэн шийдвэргүй байгаа тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийг бүрэн нотлохгүй байна. Авто тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлыг газар дээр нь шалгаж үзэхэд гэрэл дохио нь эвдэрсэн, толь нь байхгүй, тэвш сольсон, тоормос барихгүй, улсын дугаарын тоо арилсан,	

бүдгэрсэн, улсын дугаарын урд болон хажуугийн дугаар өөр зэрэг тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох бүрэн бүтэн байдлыг хангаагүй тээврийн хэрэгслүүд байв.

13-51 СБА Toyota Dyna авто машин эвдрээд 5 дугаар сарын 15-ны өдрөөс хойш засвартай байгаа, жолооч Б.Хосбаярын гэрийн хашаанд, 16-74 СЭА Mitsubishi Canter, 13-41 СЭА Isuzu elf автомашин байгууллагын гадна, 66-19 СЭА Daewoo Novus өргөгчтэй кран автомашин Ч.Мэндхүү /Хот тохижилтын газрын жолоочоор ажиллаж байгаад 2023 оны 8 сард ажлаасаа гарсан/-н гэрийн хашаанд тус тус байсан нь байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтгүй зэрэг үйлдэл нь албан хаагчдаас гаргасан удирдлагын менежмент хангалтгүй, байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах мэдлэг чадвар дутмаг гэсэн гомдол дурдсан асуудал үндэслэлтэй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

1. MNS 4598: 2020 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлагын 5.5 *"Замын хөдөлгөөнд оролцох авто тээврийн хэрэгсэл нь техникийн хувьд бүрэн бүтэн, техникийн үйлчилгээ, тохиргоог бүрэн хийсэн, үйлдвэрийн хийцийг өөрчлөн тоноглоогүй, үйлдвэрлэгчийн он, арлын дугаар засварлаагүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, шаардлага хангасан, замын хөдөлгөөнд оролцох эрхийн гэрчилгээ авсан байна"* зөрчсөн байна.
2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.13 "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих,... тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх "

Асуудлын үндсэн шалтгаан:

- Удирдлагын зүгээс үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хог тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаагүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад авах арга хэмжээг зохион байгуулаагүй, удирдлагын хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй зэрэг удирдлагын шийдвэр гаргалт үр дүнгүй оновчтой бус байгаагаас голлон шалтгаалсан байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Байгууллагын үндсэн чиг үүрэг, зорилт хангагдахгүй байх, үр ашиггүй ажиллах, албан хаагчдын хөдөлмөрийн нийгмийн баталгаа буурах сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Шийдвэр:

- MNS 4598: 2020 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлагыг хэрэгжүүлж ажиллах,
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.13 "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх" гэсний дагуу өмч хамгаалах зөвлөл нь хяналт тавьж, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй ажил үйлчилгээг үзүүлэхгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв

Илэрсэн асуудал 8	Хог тээврийн зориулалттай автомашины зарим эд ангийг сольж, ачааны зориулалттай болгон өөрчилсөн байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал:	Тус байгууллагын улсын бүртгэлийн 13-51 СБА дугаартай Toyota Dyna маркийн автомашин, 13-41 СБА дугаартай Isuzu elf, зэрэг хог тээврийн зориулалттай тусгай хэрэгслийн шахуурга нь цаашид ашиглах боломжгүй болсон үндэслэлээр порентор болон портер автомашины тэвчийг орлуулан тавьж тээврийн хэрэгслийг ачааны зориулалттай болгон өөрчилсөн шалгалтын явцад тогтоогдсон нь гомдолд дурдсан асуудал үндэслэлтэй байна.

Энэ нь тухайн тээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчлөн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа нь сөргөөр нөлөөлсөн, үйл ажиллагааны үр дүнг бууруулсан нөхцөл байдал тогтоогдоогүй боловч, тээврийн хэрэгслийн техникийн үзүүлэлт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор бичиг баримтын зөрчил үүсгэж байгаа нь техникийн хяналтын үзлэгээр хамрагдахад тэнцэхгүй байх нөхцөл бүрдсэн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

MNS 4598: 2020 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага "Замын хөдөлгөөнд оролцох авто тээврийн хэрэгсэл нь техникийн хувьд бүрэн бүтэн, техникийн үйлчилгээ, тохиргоог бүрэн хийсэн, үйлдвэрийн хийцийг өөрчлөн тоноглоогүй, үйлдвэрлэгчийн он, арлын дугаар засварлаагүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, шаардлага хангасан, замын хөдөлгөөнд оролцох эрхийн гэрчилгээ авсан байна"

Асуудлын үндсэн шалтгаан:

- Тээврийн хэрэгсэлд техникийн засвар үйлчилгээг хийхдээ үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэм, зааварчилгааг мөрдөж ажиллаагүй, шаардлагатай засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийдэггүйгээс шалтгаалсан байна.
- Тээврийн хэрэгслийн тэвхийг солихдоо сум орон нутгийн удирдлагууд болон мэргэжлийн байгууллагат мэдэгдэж зөвлөгөө аваагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Зөвхөн тусгай зориулалтын ажлын зорилгоор бус ачааны зориулалтаар ашиглах нөхцөл бүрдсэн
- Техникийн хяналтын үзлэгт тэнцэхгүй байх нь замын хөдөлгөөнд оролцох боломжгүй болж байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө.

Шийдвэр:

Цаашид тээврийн хэрэгслийг зориулалт өөрчлөгдөх тохиолдолд авто тээврийн үндэсний төвийн улсын бүртгэлийн мэдээллийн санд холбогдох журмын дагуу бүртгүүлж зөрчилгүй бүрэн тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оруулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 9	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд тус байгууллагад Хогны машин худалдан авахаар батлагдсан боловч худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа техникийн тодорхойлолтыг өөрчилж кран худалдан авч нийлүүлсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: <ul style="list-style-type: none"> ➢ Сайхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 20 тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, Сайхан сумын Засаг даргын тамгын газрын захиалгаар 80,000,000 төгрөгийн Хогны машин худалдан авах тендер зарлаж уг тендэрт 79,800,000 төгрөгийн үнийн саналаар "Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоо" шалгарч кран автомашин авсан байна. ➢ Техникийн тодорхойлолтоор машины даацыг 5 тн гэж заасан боловч , тээврийн гэрчилгээ дээр 4.5 тн даацтай байна. 	
Байх ёстой шаардлага /шалгуур/: <p>Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.",</p>	
Асуудлын үндсэн шалтгаан: <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хогны машин худалдан авахдаа нэр төрлөөр нь бус төсөвт тусгаагүй кран машин авч төсвийг зориулалт бусаар ашигласан байна.</p>	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	

<ul style="list-style-type: none"> ▪ Хууль зөрчих, дарга, удирдлага, худалдан авах комисс эрх мэдлээ урвуулан ашиглах, ▪ Төсвийг үр ашиггүй захиран зарцуулах
<p>Шийдвэр: Сумын ИТХ-ын 2023 оны 20 тогтоолоор батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэршил өөрчилж худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

Илэрсэн асуудал 10	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрийн орлогын зарим хэсгийг албан хаагчдын дансаар дамжуулан хураан авч төсөвт төвлөрүүлээгүй 2,350,000.0 төгрөгийн зөрчил илэрлээ
Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал: Албан хаагчдын дансаар зориулалт бусаар мөнгө дамжуулан ашигласан эсэхийг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын нягтлан Б.Хосчимэгийн /5168694105/ дансаар /1-р сургуулийн хашаан дахь модны хэлбэржүүлэх тайралт үнэ хөлсний орлого/ нийт 700,000 төгрөг, 2. Байгууллагын нярав Б.Батчимэгийн /5901090462/ дансаар /Кран машины орлого/ нийт 650,000 төгрөг, Байгууллагын тохижилт үйлчилгээ хариуцсан зохион байгуулагч А.Отгонцэцэгийн дансаар /сумын нийтийн эзэмшлийн талбайн модноос хэлбэржүүлэх тайралт хийсэн 1 настай улиасны мөчир Зоригт гэх хувь хүнд борлуулсны орлого/ 1,000,000 төгрөг нийт 2,350,000 төгрөгийг албан хаагчдын дансаар дамжуулан авч байгууллагын үйл ажиллагаанд 1,229,300 төгрөгийг зарцуулсан /Байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан зардал нь 16-74 СЭА Mitsubishi Canter-н моторын халаагч 4 ширхгийг 300,000 төгрөгөөр, овоот хорооллын гэрэлтүүлгийн тэжээлийн ерөнхий аппарат авахад 42,000 төгрөгийг, цахилгааны зардалд 12,300 төгрөгийг, астачерийн засварт 350,000 төгрөгийг, мод тайрах хөрөөний ир, шугам төмрийг авахад 40,000 төгрөгийг, паркийн дугуйн замын 26 ширхэг гэрэлтүүлгийн газардуулгыг аж ахуйн аргаар гүйцэтгэж гэрэлтүүлгийн тэжээл авч ажилд оруулсан засварын зардалд 485,000 төгрөг/ гэх боловч санхүүгийн анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. 3. Гомдолд дурдсан байгууллагын үйл ажиллагааны орлогыг зориулалт бусаар албан хаагчдын дансаар дамжуулан хувьдаа зарцуулсан үндэслэлтэй байгаа нь хяналт шалгалтын явцад баримтаар нотлогдож байна. 	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", Авлигын эсрэг тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь "албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх" 	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <ul style="list-style-type: none"> • Дарга, удирдлага эрх мэдлээ урвуулан ашиглаж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрийн орлогын дансанд төвлөрүүлэхгүй, зориулалт бусаар захиран зарцуулсан. • Санхүүгийн ажилтнуудын хувийн харилцах дансаар орлогыг дамжуулсан 	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <ul style="list-style-type: none"> • Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэхгүй байх, зориулалт бусаар захиран зарцуулах • Ашиглан, залилан гарах 	
<p>Шийдвэр: Байгууллагын үйл ажиллагаанаас бий болсон орлогыг албан хаагчдын дансаар зориулалт бусаар дамжуулан зарцуулсан 2,350,000 төгрөгийг нөхөн төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.</p>	

Илэрсэн асуудал 11	Анхан шатны баримтаар нотлогдоогүй 2,218,516.0 төгрөгийн шатахуун олгосон байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал:	
<p>Тус газрын 2023, 2024 оны шатахууны зарцуулалтын тайлагналыг санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлтэй тулган тооцооллыг дахин хянаж үзэхэд жолоочийн тооцооны хуудасгүй зарлагаар бүртгэсэн 570,000.0 төгрөг, шатахуун зарцуулалтын нормыг мөрдөөгүйгээс 1,648,516 төгрөгийн шатахууныг илүү олгосон байна.</p> <p>Хот тохижилтын газрын даргын 2023 оны 01 сарын 03-ны өдрийн А/3 тоот тушаалаар автомашинуудын 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг 26 литр, 2024 оны 01 сарын 02-ны өдрийн А/2 тоот тушаалаар 29-31 литрээр тус тус тогтоохдоо сорил, туршилтыг явуулаагүйгээс үндэслэлгүй тогтоосон. Жишээ нь 2024 онд 854,075.05 төгрөгийн шатахууныг дутуу олгосон харагдаж байгаач өдөр бүр явах ёстой ажил үүргээ хийж гүйцэтгэсэн байна.</p>	
Байх ёстой шаардлага /шалгуур/:	
<p>Монгол Улсын зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын 3 дугаар хавсралт “Шатахуун зарцуулалтын жишиг норм тогтоогдоогүй автомашины хувьд автомашины үйлдвэрлэгчийн тогтоосон шатахуун зарцуулалтын хяналтын норм болон ашиглалтын нөхцөлөөс хамаарч хяналтын зарцуулалтын өөрчлөлтийн хэмжээг илэрхийлэх коэффициентын тусламжтайгаар тооцооны аргаар тогтоож болно. Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг (Нжишиг) хяналтын зарцуулалтын тусламжтайгаар дараах томъёогоор тодорхойлно: $H \text{ жишиг} = H \text{ хяналт} * K_e [1]$,</p> <p>Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;”, 5.1.5 “хариуцлагатай байх”</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалт “.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дах заалт “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”,</p> <p>Сангийн сайдын 2017/347 тоот тушаалаар шинэчлэгдсэн санхүүгийн анхан шатны баримтыг хөтлөөгүй. “Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана.”</p>	
Асуудлын үндсэн шалтгаан:	
<ul style="list-style-type: none"> • Тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын нормыг буруу тогтоосон • Шатахуун зарцуулалтад байгууллагын дарга, нягтлан бодогч нар бүртгэлийн хяналт хангалтгүй хэрэгжүүлснээс баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэх, 100 км зарцуулах нормыг мөрдөөгүйгээс илүү олгох үндсэн шалтгаан болсон байна. 	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	
<ul style="list-style-type: none"> • Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг мөрдөхгүй байх. • Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах. 	
Шийдвэр:	
Шатахууны зарцуулалтад анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, илүү олгосон нийт 2,218,516 төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.	

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Сайхан сумын Хот тохижуулах газрын албан хаагчдаас тус байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, төсөв, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт, зарцуулалт, үндэслэлгүй ажлаас халсан зэрэг хууль бус гаргасан гомдлыг шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн **“Хангалтгүй”** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Хангалтгүй	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “эхлэлийн буюу 1-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 80%-иас дээш нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР, СХШУБ *Ц. Уртнасан* ЦУРТНАСАН

ДОТООД АУДИТОР *Г. Дорждэрэм* Г.ДОРЖДЭРЭМ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ДАРГА *Т. Одсүрэн* Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:

САЙХАН СУМЫН ХОТ

ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ДАРГА *Б. Энхбаяр (Тусгайбартагч)* Б.ЭНХБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ: *Б. Хосбаяр* Б.ХОСБАЯР

НЯРАВ: *Б. Батчимэг* Б. БАТЧИМЭГ



Илэрсэн зөрчлийн нэгтгэл:

№	Зөрчлийн товч утга	Нийт	Нийт	Шийдвэрлэлт мөнгөн дүн (мянган төгрөгөөр)					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2023 оны 7, 9 дүгээр саруудад албан хаагчдын цалин, хөлсийг сар дамнуулан олгосон.	1	-					1	
2	Албан хаагчдад цалин хөлс, нэмэгдэл орсон өөрчлөлтийг шийдвэрийг албан хаагчдад тухай бүр мэдэгдээгүй байна.	1	-					1	
3	Хот тохижилтын газрын хүний нөөц тогтворгүй, ажилтны санаачилгаар болон ажил олгогчийн санаачилгаар 2023, 2024 онд нийт ажилчдын 25-50 хувь нь хөдөлмөрийн гэрээг цуцалсан байна.	1	-					1	
4	2024 онд хог хаягдлын хураамжийн орлого 32,671,600 төгрөгийг, ААНБ болон оршин суугчдаас авах авлага 56,118,000 төгрөгийг нийт 88,789,600 төгрөгийг санхүүгийн CTS NNB программд бүртгээгүй байна байна.	1	88,789.6			1	88,789.6		
5	Худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийг баримтлаагүй,	1	33,000.0			1	33,000.0		
6	Хог тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ цаг хугацаандаа хийдэггүй, ашиглалтын байдал хангалтгүй	1						1	
7	Хог тээврийн зориулалттай автомашины зарим	1						1	

	эд ангийг сольж, ачааны зориулалтай болгон өөрчилсөн								
8	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд тус байгууллагад Хогны машин худалдан авахаар батлагдсан боловч худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа техникийн тодорхойлолтыг өөрчилж кран худалдан авч нийлүүлсэн байна.	1	80,000.0				1	80,000.0	
9	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрийн орлогын зарим хэсгийг албан хаагчдын дансаар дамжуулан хураан авч төсөвт төвлөрүүлээгүй.	1	2,350.0	1	2,350.0				
10	Анхан шатны баримтаар нотлогдоогүй 2,218,516.0 төгрөгийн шатахуун олгосон	1	2,218.5	1	2,218.5				
Нийт дүн		11	206,358.1	2	4,568.5	2	121,789.6	7	80,000.0



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АКТ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 11/32-03

Сүхбаатар сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.4, 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн №2 тоот удирдамжийн дагуу Сайхан сумын Хот тохижилтын газрын 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрийн орлогын зарим хэсгийг албан хаагчдын дансаар дамжуулан хураан авч төсөвт төвлөрүүлээгүй 2,350,000.0 (Хоёр сая гурван зуун тавин мянга) төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", Авлигын эсрэг тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь "албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд төлбөрийн акт барагдуулах, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын үйл ажиллагаанаас бий болсон орлогыг албан хаагчдын дансаар дамжуулан хураан авсан 2,350,000.0 (Хоёр сая гурван зуун тавин мянга) төгрөгийг нөхөн төлүүлж, Сэлэнгэ аймгийн Төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.

4324006008

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд нотлох баримтын хамт ирүүлэхийг Сайхан сумын Хот тохижилтын газрын дарга С.Энхбаяр, нягтлан бодогч Б.Хосчимэг нарт хариуцуулав.
3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ Д.УРТНАСАН



САЙХАН СУМЫН ХОТ
ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ХОСЧИМЭГ





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АКТ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 10/32-03

Сүхбаатар сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.4, 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаартай удирдамжийн дагуу Сайхан сумын Хот тохижилтын газрын 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар анхан шатны баримтаар нотлогдоогүй 2,218,516.0 (Хоёр сая хоёр зуун арван найман мянга таван зуун арван зургаа) төгрөгийн шатахуун олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 дах заалт "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд төлбөрийн акт барагдуулах, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтаар шатахуун зарцуулалт нотлогдоогүй, илүү олгосон 2,218,516.0 (Хоёр сая хоёр зуун арван найман мянга таван зуун арван зургаа) төгрөгийг нөхөн төлүүлж, Сэлэнгэ аймгийн Төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.

4324006006

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд нотлох баримтын хамт ирүүлэхийг Сайхан сумын Хот тохижилтын газрын дарга С.Энхбаяр, нягтлан бодогч Б.Хосчимэг нарт хариуцуулав.
3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ



Ц.УРТНАСАН

ЗӨВШӨӨРСӨН:
САЙХАН СУМЫН ХОТ
ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХБАЯР
НЯГТЛАН БОДОГЧ
Б.ХОСЧИМЭГ





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 31/32-03

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.4, 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар удирдамжийн дагуу Сайхан сумын Хот тохижилтын газрын 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар 2024 онд 33,000,000 (Гучин гурван сая) төгрөгийн төсөвт өртөгтэй шатахууны худалдан авалтыг шууд гэрээ байгуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.”, ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1. дэх “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна.”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ийн “1. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар-Бараа-20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д “Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цаашид худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөж зөрчлийг

4324005028

дахин давтан гаргахгүй ажиллаж биелэлтийг 2024 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд нотлох баримтын хамт ирүүлэхийг Сайхан сумын Хот тохижилтын газрын дарга С.Энхбаяр, нягтлан бодогч Б.Хосчимэг нарт даалгав.

2. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ Ц.УРТНАСАН



ЗӨВШӨӨРСӨН:

САЙХАН СУМЫН ХОТ
ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ДАРГА
ДАРГА С.ЭНХБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ХОСЧИМЭГ





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 30/32-03

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.4, 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаартай удирдамжийн дагуу Сайхан сумын Хот тохижилтын газрын 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар 2024 онд хог хаягдлын хураамжийн орлого 32,671,600 (Гучин хоёр сая зургаан зуун далан нэгэн мянга зургаан зуун) төгрөг, Аж ахуйн нэгж байгууллага болон оршин суугчдаас авах авлага 56,118,000 (Тавин зургаан сая нэг зуун арван найман мянга) төгрөг, нийт 88,789,600 (Наян найман сая долоон зуун наян есөн мянга зургаан зуу) төгрөгийг санхүүгийн санхүүгийн тайланд бүртгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт".14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ",14.4.5 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ "бүх орлого" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ажлаах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын үйл ажиллагааны орлого, болон аж ахуй нэгж, иргэдээс авах хог хаягдлын хураамжийн авлага санхүүгийн тайланд бүрэн тусгаж, дахин зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж биелэлтийг 2024 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд нотлох баримтын хамт

4324005026

ирүүлэхийг Сайхан сумын Хот тохижилтын газрын дарга С.Энхбаяр, нягтлан бодогч Б.Хосчимэг нарт даалгав.

2. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОТООД АУДИТОР САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ ЦУРТНАСАН



ЗӨВШӨӨРСӨН:

САЙХАН СУМЫН ХОТ
ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН
ДАРГА (С.ЭНХБАЯР)
НЯГТЛАН БОДОГЧ
Б.ХОСЧИМЭГ